




СОЁЛЫН ЯАМ







МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ
КИНО УРЛАГИЙН
ЗӨВЛӨЛ

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНД ТӨСӨЛ МЭДҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

(ТӨСЛИЙН ТӨРӨЛ: КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТАНД ОРОЛЦОХ САНХҮҮЖИЛТ)

Төслийн төрөл: КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТАНД
ОРОЛЦОХ САНХҮҮЖИЛТ

№1	КИНО УРЛАГИЙН ДЭМЖИХ САНГИЙН СИСТЕМД НЭВТРЭХ
1.1	<p>1. Кино урлагийг дэмжих санд төсөл илгээхдээ www.kuds.filmmongolia.gov.mn хаягт хандан хувь хүн эсвэл албан байгууллагаар бүртгэл үүсгэн системд нэвтэрч төсөл мэдүүлнэ.</p> <p>2. Кино урлагийг дэмжих сангийн системд бүртгэлээр нэвтрэн орсны дараа “КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТАНД ОРОЛЦОХ САНХҮҮЖИЛТ” гэсэн формыг сонгож орно.</p> <div data-bbox="722 682 997 884" style="text-align: center;">  <p>Кино наадам болон сургалтанд оролцох санхүүжилт</p> </div>  <p>3. “КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТАНД ОРОЛЦОХ САНХҮҮЖИЛТ” форм руу орж “+ Нэмэх” гэсэн товчийг дарснаар төслийн хүсэлт илгээх талбарууд гарч ирнэ.</p> <div data-bbox="552 1045 1159 1199" style="text-align: center;">  <p>КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ</p> <div style="border: 1px solid white; border-radius: 15px; padding: 5px 15px; display: inline-block; margin-left: 20px;">+ Нэмэх</div>  </div>
№2	“ТӨСЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага
	<p>Кино наадам болон сургалтанд оролцох санхүүжилт форумын “Төслийн хүсэлт гаргагчийн мэдээлэл” талбарт дараах 3 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өргөдөл / Албан бичиг • Иргэний үнэмлэхийн хуулбар / Байгууллагын гэрчилгээний хуулбар (<i>Та хувь хүнээр төсөл мэдүүл буй тохиолдолд өөрийн иргэний үнэмлэхийн цахим хуулбарыг файлаар хавсаргана. Хэрэв албан байгууллагаар мэдүүлж буй тохиолдолд тухайн байгууллагын гэрчилгээг хавсаргана.</i>) • Гадаад хэлний түвшин тодорхойлох бичиг баримт (<i>гадаад хэл дээрх баримт бичиг бол орчуулгын хамт ирүүлэх</i>)
2.1	ӨРГӨДӨЛ / АЛБАН БИЧИГ


	<p>Тухайн төсөл, арга хэмжээ нь “Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкнийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам” -ын 1.4-д заасан зөрчилгүй. Кино бүтээх төсөл нь тус журмын 2.2.3, 2.2.4 -д заасан чиглэлүүдийн нэг болон түүнээс дээш зүйлд нийцэж буйг өргөдөлдөө сайтар тусгасан байна. Мөн төслийн хэрэгжүүлэлтийн аль үе шат, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг бичиж, Кино урлагийг дэмжих сангаас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ, тус үнийн дүн нь төслийн нийт төсвийн хэдэн хувь болохыг дурдсан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо: 150-300</p>
2.2	<p>ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ХУУЛБАР / БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР Байгууллагаар төсөл мэдүүлж буй тохиолдолд байгууллагын гэрчилгээний хуулбар (нүүр болон ар тал) хавсаргана. Хэрэв хувь хүнээр төсөл мэдүүлж буй тохиолдолд иргэний үнэмлэхийн цахим хуулбарыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
2.3	<p>ГАДААД ХЭЛНИЙ ТҮВШИН ТОДОРХОЙЛОХ БИЧИГ БАРИМТ Олон улсын кино наадам болон кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтад оролцогчдын гадаад хэлний мэдлэгийг тодорхойлох баримт бичгийг хавсаргана. <i>(Хэрэв гадаад хэл дээр бол орчуулгын хамт илгээнэ.)</i></p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
№3	<p>“ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага</p>
	<p>Кино наадам болон сургалтанд оролцох санхүүжилт форумын “Төслийн ерөнхий мэдээлэл” талбарт дараах 6 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Кино наадамд оролцох уран бүтээлч болон уран бүтээлийн танилцуулга / сургалцагч болон сургалт, сургалцах мэргэжлийн танилцуулга • Кино наадмын урилга эсвэл бүртгэл / сургууль, сургалтанд элсэх болзол хангасныг илтгэх баримт бичиг эсвэл сурч байгааг нотлох лавлагаа • Зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээд бол туршлагын талаарх мэдээлэл • Төслөөс гарах үр дүн, нийгмийн ач холбогдол • Кино наадамд оролцох хөтөлбөр / сургалтын хөтөлбөр төлөвлөгөө • Бусад <i>(Кино наадам / сургалтад оролцохтой холбоотой үйл ажиллагааны талаарх нэмэлт мэдээлэл)</i>
3.1	<p>Кино наадамд оролцох уран бүтээлч болон уран бүтээлийн танилцуулга / сургалцагч болон сургалт, сургалцах мэргэжлийн танилцуулга</p>




	<p>Олон улсын кино наадамд оролцож буй уран бүтээлч болон уран бүтээлийн товч танилцуулга / сургалтын болон суралцагч, суралцах мэргэжлийн талаарх танилцуулга байна. Энэхүү танилцуулгад тухайн кино наадам / сургалт болох улс орох, тус наадмын / сургалтын үргэлжлэх хугацаа, албан ёсны хэл, кино наадам / сургалтад шаардлагатай хэрэглэгдэхүүн зэргийг тодорхой тусгасан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.2	<p>Кино наадмын урилга эсвэл бүртгэл / сургууль, сургалтанд элсэх болзол хангасныг илтгэх баримт бичиг эсвэл сурч байгааг нотлох лавлагаа</p> <p>Тухайн олон улсын кино наадмаас ирүүлсэн албан ёсны урилга, бүртгэл / сургуулийн урилга, сургалтад хамрагдахыг нотолсон албан захиа (хэрэв сургуульд суралцаж буй тохиолдолд суралцаж буйг нотлох сургуулийн лавлагаа) зэргийг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.3	<p>ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭД БОЛ ТУРШЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</p> <p>Хэрэв олон улсын кино наадмын маркетэд оролцож буй дистрибьютер компани бол өмнө нь адил төстэй үйл ажиллагаанд оролцож байсан туршлагын мэдээллийг танилцуулга болгон бэлтгэж ирүүлнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.4	<p>ТӨСЛӨӨС ГАРАХ ҮР ДҮН, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДОЛ</p> <p>Тухайн олон улсын кино наадамд оролцсоноор ямар дэвшил гарах, гадаад харилцаа холбоогоо хэрхэн өргөжүүлэх / сургалтад хамрагдсанаар мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хэрхэн хөгжүүлэх зэрэг төслийг хэрэгжүүлснээр гарах нийгэм, эдийн засгийн үр нөлөөг бичнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 150-300</p>
3.5	<p>Кино наадамд оролцох хөтөлбөр / сургалтын хөтөлбөр төлөвлөгөө</p> <p>Тухайн олон улсын кино наадамд оролцох хөтөлбөрийн танилцуулга, наадмын хүрээн дэхь өөрийн үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөр / сургууль, суралцах хөтөлбөрийн танилцуулга, суралцах батлагдсан хөтөлбөрийг хавсарган ирүүлнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.6	<p>Бусад</p> <p>Олон улсын кино наадам / сургалтад оролцохтой холбоотой үйл ажиллагааны талаарх нэмэлт мэдээллийг хавсарган илгээнэ.</p>


	Хавсаргах файлын төрөл: PDF
№4	“ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага
	<p>Кино наадам болон сургалтанд оролцох санхүүжилт форумын “Төслийн санхүүжилтийн мэдээлэл” талбарт дараах 1 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Хөрөнгө нотолгооны баримт бичиг
4.1	<p align="center">ХӨРӨНГӨ НОТӨЛГӨӨНЫ БАРИМТ БИЧИГ</p> <p>“Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкныг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам”-ын 4.7-д заасны дагуу тухайн төслийн нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг төсөл мэдүүлэгч шийдвэрлэсэн байх шаардлагатай тул тухайн хувь хэмжээг нотлох 6 сарын дансны хуулга аль эсвэл, албажсан баримт бичиг, гэрээг хавсарган ирүүлнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>


ЖИЧ :


- “КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТАНД ОРОЛЦОХ САНХҮҮЖИЛТ” -ийн төслийн мэдүүлэгт хавсаргах файлуудад энэхүү зөвлөмжид заасан холбогдох агуулгыг боловсруулан бэлтгэж, стандартыг мөрдөж шаардлага хангасан, үнэн бодит мэдээлэлтэй материал илгээх ёстойг анхаарна уу.
- Дараах талбаруудыг бөглөхдөө  тэмдэг дээр дарж гарч ирэх хүснэгтэд холбогдох мэдээллийг бичнэ. Үүнд:**
 - “Төслийн санхүүжилтийн мэдээлэл” талбарын **“Санхүүгийн задаргаа”** хэсэг болно.

Жишээ нь:

Санхүүгийн задаргаа 



Санхүүгийн задаргаа 

ДД	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	ТАЙЛБАР	...
1				

3. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВ



СОЁЛЫН ЯАМ

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНД ТӨСӨЛ
МЭДҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ



Төслийн мэдүүлэг бөглөх явцад “**Баталгаажуулалтын төлөв**” хэсгийн “**Хадгалаад засварлах / Update**” төлөвийг сонгон “**Хадгалах**” товчийг дарж системд оруулсан мэдээллээ хадгална. Мэдүүлгийн бүх тайлбарыг бөглөж дууссаны дараа тухайн хэсгийн “**Баталгаажуулж илгээх/ Submit**” төлөвийг сонгож “**Хадгалах**” товчийг дарж төслөө илгээнэ.

Баталгаажуулж илгээх / Submit

Хадгалаад засварлах / Update

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ



+976 (51) 262226
www.kuds.filmmongolia.gov.mn
Mongolian National Film Council